



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ

2018 оны 04 сарын 03 өдөр

Дугаар 41

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө балансаас балансад
шилжүүлэх тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 30 дугаар зүйлийн 2, 31 дүгээр зүйлийн 1, 2, 3 дахь хэсэг, “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 5.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Эрчим хүчний хөгжлийн төв” төрийн өмчит үйлдвэрийн газрын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, нийт 163,500,000.00 (нэг зуун жаран гурван сая таван зуун мянган) төгрөгийн балансын үнэ, 47,759,014.40 (дөчин долоон сая долоон зуун тавин есөн мянга арван дөрвөн төгрөг дөчин мөнгө) төгрөгийн хуримтлагдсан элэгдэл бүхий хавсралтад заасан үндсэн хөрөнгийг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт балансаас балансад шилжүүлсүгэй.

2. Эрчим хүчний яамны Төрийн нарийн бичгийн дарга 3. Мэндсайхан болон тогтоолд заасан байгууллагын дарга нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Хөрөнгө хүлээлцэх ажлыг байгууллагын өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулах;


2.2. Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.3. Энэ тогтоолын биелэлтийг 2018 оны 2 дугаар улиралд багтаан Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлэх.

3. Энэхүү тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, хяналтын хэлтэс (Ц.Түвшинзаяа)-т үүрэг болгосугай.

ДАРГА

ЗАХИРГАА, ХУУЛЬ ЗҮЙН ХЭЛТСИЙН
ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦӨТГЭГЧ




Ц.НЯМ-ОСОР

Э.ЭРДЭНЭХИШИГ

0001541

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2018 оны 04 дүгээр сарын 03 -ны өдрийн
4/ дугаар тогтоолын хавсралт



**"Эрчим хүчний хөгжлийн төв" төрийн өмчит үйлдвэрийн газрын балансаас
Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын балансад шилжүүлэх хөрөнгө**

Д/д	Автомашины төрөл, зориулалт, улсын дугаар	Ашиглалтанд орсон он	Нийт гүйлт /км/	Нийт үнэ (төгрөг)	Хуримтлагдсан элэгдэл (төгрөг)	Үлдэх өртөг (төгрөг)
1	"Ниссан патрол Y62", суудлын, 44-89 УНУ	2016	57,555.00	163,500,000.00	47,759,014.40	115,740,985.60
НИЙТ ДҮН:				163,500,000.00 (нэг зуун жаран гурван сая таван зуун мянган)	47,759,014.40 (дөчин долоон сая долоон зуун тавин есөн мянга арван дөрвөн төгрөг дөчин мөнгө)	115,740,985.60 (нэг зуун арван таван сая долоон зуун дөчин мянга есөн зуун наян таван төгрөг жаран мөнгө)